**ЗӨВШӨӨРСӨН:**
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА...........Д.ЭРДЭМБИЛЭГ

**БАТЛАВ:**
ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ СУДЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА......................Л.ГАНБОЛД

ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН

**“ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ СУДЛАЛ”**

ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ИНДЕКС: s(r)091222
ХУГАЦАА: 2 жил

**ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ СУДЛАЛЫН ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛСАН БАГ:**

**Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл**

| | |
|---|---|
| Л.Ганболд | Эрүүл Мэндийн Яамны Яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, Ерөнхий мэргэжилтэн, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Анагаах Ухааны Сургуулийн Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэг судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, Профессор; |
| С.Алтансүх | Эрүүл Мэндийн Яамны Яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, Анагаах ухааны докторант, Клиникийн Профессор, Зөвлөх зэргийн эмч; |
| Р.Баянмөнх | Эрүүл Мэндийн Яамны Яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Цэргийн төв эмнэлгийн эмнэлзүй эрхэлсэн орлогч дарга, Монголын улсын хүний гавьяат эмч, Анагаах ухааны докторант, Клиникийн Профессор, Зөвлөх зэргийн эмч; |
| Ж.Уламсайхан | Эрүүл Мэндийн Яамны Яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, Анагаах ухааны докторант, Ахлах зэргийн эмч; |
| О.Янжив | Эрүүл Мэндийн Яамны Яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, Анагаах ухааны магистр, Ахлах зэргийн эмч; |
| Л.Мөнхтуяа | Эрүүл Мэндийн Яамны Яаралтай тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, Анагаах ухааны докторант, Тэргүүлэх зэргийн эмч; |

**Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл**

| | |
|---|---|
| Б.Эрдэнэболд | Гэмтэл согог судлалын үндэсний төвийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, Анагаах ухааны магистр, Ахлах зэргийн эмч; |
| М.Цэнгэлмаа | Цэргийн төв эмнэлгийн хордлогын яаралтай тусламжийн үндэсний төвийн эмнэлзүй хор судлаач, Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч |
| Г.Ариунцэцэг | Монгол Япон эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч; |

| | |
|---|---|
| Т.Чойсүрэн | Цэргийн төв эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч; |
| А.Болормаа | Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн их эмч; |

**Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгийн төлөөлөл**

| | |
|---|---|
| Ө.Анхболд | Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Монголын эрүүл мэндийн үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд дарга, Яаралтай тусламжийн ахлах зэргийн эмч; |
| Т.Тодхүү | Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Төрийн тусгай хамгаалалтын газрын ахлах ажилтан, Яаралтай тусламжийн ахлах зэргийн эмч; |
| Д.Солонго | Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тасгийн эрхлэгч, Ахлах зэргийн эмч; |

**ХЯНАСАН:**

| | |
|---|---|
| П.Эрхэмбаяр | Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр; |
| Б.Туяа | Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын хүний нөөцийн мэргэшил, сургалт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн; |
| Д.Дондогмаа | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн; |

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2022 оны 9. дүгээр сарын 1. –ны өдрийн
.13.. дугаар тогтоолоор зөвшөөрөв

# ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН
# "ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ СУДЛАЛ"
# ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Засгийн Газрын 138 дугаар тогтоол "Үндэсний түргэн тусламжийн сүлжээ" хөтөлбөрт яаралтай тусламжийн мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх тоног төхөөрөмжөөр хангах нэгдсэн тогтолцоонд оруулах талаар заасан байна.

Монгол Улсын Эрүүл Мэндийн Сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/814 дүгээр тушаалд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үлгэрчилсэн журмын дагуу зохион байгуулж байна.

Монгол улсын аль ч шатны эмнэлгүүдэд яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай эмч мэргэжилтэн, эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийн хангамжийн хүрэлцээ муу, байнгын дутагдалтай байсан, одоо ч хангалтгүй байгаа. Энэ тухай мянганы сорилын сангийн шинжээчдийн эмнэлгийн яаралтай тусламжийн байдалд хийсэн дүгнэлтээр "Монгол улсын хэмжээнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх боломжгүй" гэж үнэлэгдсэн байдаг.

Монгол улсын хэмжээнд нас баралтын түвшин жил бүр нэмэгдэж эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай архаг болон цочмог өвчлөл, осол гэмтэл нь нас баралтын тэргүүлэх шалтгаан болж мэргэшлийн яаралтай тусламжийн үйлчилгээг үзүүлэх эмч мэргэжилтэн туйлаас чухал байна.

Эрүүл Мэндийн Тусламж Үйлчилгээний тухай хуульд эмнэлгийн яаралтай тусламжийг тусгай зөвшөөрөл бүхий өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, клиник, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг үзүүлэх бөгөөд өрхийн эрүүл мэндийн төвөөс бусад байгууллага яаралтай тусламжийн нэгжтэй байна гэж заасан байдаг.

Монгол улсад 2014 оноос яаралтай тусламжийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн бөгөөд 2016-2021 онуудад нийт 82 яаралтай тусламжийн эмчийг бэлтгэн төгсгөөд байгаа хэдий ч улсын хэмжээнд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн яаралтай тусламжийн эмч дутмаг, 10 хүрэхгүй хувийг эзэлж байгаа нь хангалтгүй байсаар байна.

## ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО:

Сум, тосгоны эрүүл мэндийн төв, клиник, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд ажиллах Яаралтай тусламжийн чиглэлээр мэргэшлийн түвшинд ур чадвар, дадлыг эзэмшсэн, гамшиг ослын үед ажиллах чадвартай, нийгмийн хэрэгцээг хангах, хүн хоорондын харилцааны үнэлэмжийг дээдэлсэн, эрдэм шинжилгээ, өвчлөлийн бүтэц анагаах ухааны ололт дэвшлийг уялдуулан ойлгох зэрэг хандлага, чадамжид суурилсан олон бүрэлдэхүүн хэсгийг агуулсан үнэ цэнэ бүхий мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА:

Эмчийн ёс зүйн хүрээнд өвчин эмгэгийн төрлөөс үл шалтгаалан, яаралтай тээвэрлэгдэн ирсэн өвчтөнг нэн түрүүнд хүлээн авч эхний оношилгоо, эмнэлгийн тусламжийг үзүүлж, тогтворжуулан, шаардлагатай бол холбогдох тасгийн мэргэжлийн эмчтэй хамтран тусламж үйлчилгээг шуурхай, аюулгүй гүйцэтгэх, өвчтөнг тээвэрлэх, бусад эмнэлэг болон түргэн тусламжийн багтай харилцаа холбоотой ажилласнаар бүс нутгийн яаралтай тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хамгаалах гол цөм, багана нь болж ажиллах *Яаралтай тусламжийн мэргэшсэн эмчийг* бэлтгэнэ.

## ДӨРӨВ: ЗОРИЛТ

Сургалтын хугацаанд доорх 7 цогц чадамжийг бүрэн эзэмшсэн яаралтай тусламжийн эмч бэлтгэн гаргана.

1. Яаралтай тусламжийн эмч *(Emergency physician)*
2. Яаралтай тусламжийн мэргэшсэн эмч *(Professionalism)*
3. Суралцагч *(Learner)*
4. Харилцагч *(Communicator)*
5. Хамтрагч *(Collaborator)*
6. Эрүүл мэндийн зөвлөгч *(Community Health Advocate)*
7. Зохион байгуулагч, манлайлагч *(Leader)*

Яаралтай тусламжийн мэргэжилтэн нь дээрх 7 цогц чадамж бүхий эмч болохын тулд дараах чадамжуудыг эзэмшиж гүйцэтгэж чаддаг болно.

Үүнд:

**Яаралтай тусламжийн эмч *(Emergency physician)*:**

- Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчний шинж тэмдэг, хам шинжийг *(signs and symptoms)* таньж, ялган оношлох, анхан шатны арга хэмжээг авах;
- Яаралтай тусламжийн үед хийгдэх оношилгоо, эмчилгээний гардан үйлдлийг бүрэн эзэмшиж, тусламж, үйлчилгээг аюулгүй үзүүлэх;
- Ард иргэдэд амилуулах суурь тусламжийн мэдлэг дадлагыг түгээгч,

сургагч багшаар ажиллах чадвартай байх;

- Гамшиг осол, нийтийг хамарсан гамшгийн байдал, гоц халдварт өвчин гарсан тохиолдолд гамшгийн үеийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх багийн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллах;
- Эмнэлэг хүртэлх яаралтай тусламж үзүүлэх мэргэжлийн өндөр ур чадвартай байх;
- Амь тэнссэн болон яаралтай тусламж шаардлагатай байгаа өвчтөнөөс асуумжийг оновчтой цуглуулан тухайн нөхцөлд нэн шаардлагатай үзлэгийг үр дүнтэй хийж сурах;
- Өвчтөн түүний ар гэр, эмнэлгийн бусад мэргэжилтэнтэй мэргэжлийн ёс зүйн үүднээс харилцах чадвартай болох;
- Өвчтөний өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нөөц бололцоонд тулгуурлан, өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээг шийдвэрлэх;

**Яаралтай тусламжийн мэргэшсэн эмч *(Professionalism):***

- Эрүүл мэндийн салбарт өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулж ажиллах үүргээ ухамсарлах;
- Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажилладаг байх;
- Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүдтэй хүндэтгэлтэй харилцах чадвартай байх;
- Эмнэлгийн яаралтай тусламжийн салбарт зонхилон тохиолддог шинж тэмдгүүд, хам шинжүүдийг (signs and symptoms) таньж ялган оношлон, яаралтай тусламж үзүүлдэг байх;
- Эмнэлгийн яаралтай тусламжийн салбарт зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний стандартыг зөв хэрэглэн, гардан ажилбарыг хангалттай эзэмшсэн, шаардлагатай тохиолдолд аюулгүй хийдэг байх;
- Үй олныг хамарсан осол, гэмтэл, байгалийн гамшиг, гоц халдварт өвчин эмгэг тархсан онцгой тохиолдолд ажиллах ур чадвартай байж, сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг ойлгон шинжилгээ, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх чадвартай байх;
- Гамшигт нэрвэгдсэн болон яаралтай тусламж шаардлагатай өвчтөнүүд ба тэдний ар гэрийнхэнтэй харилцах ур чадвар, ёс зүйд суралцан, өвчтөний хувийн нууцыг хадгалан, өвчтөний өвдөлт болон сэтгэлзүйн тулгамдсан асуудалд анхаарал хандуулж сурсан байх;
- Ард иргэдэд анхны тусламжийн сургалтыг зохион байгуулах, заах чадвартай байх;
- Зарим зайлшгүй шаардлагатай оношилгооны аргачлалд суралцан оношилгооны дүгнэлтийг эмчилгээ үйлчилгээнд ашиглаж сурах (ЗЦБ, яаралтай тусламжийн хэт авиан шинжилгээ, рентген зураг, лабораторийн

шинжилгээ);

- Биед нэвтрэлтэд ажилбарыг оношилгоо, эмчилгээний зорилгоор хийх чадвартай байх. Жишээ нь: төвийн венийн гуурс тавих, цээжний хөндий, хэвлийн хөндийд, давсагт шууд болон сүвээр гуурс хийх, хамрын хөндийн чихээс хийх зэрэг;
- Яаралтай тусламжийн тасгийн нэг болон хэд хэдэн өвчтөнийг ачааллын болон энгийн ачааллын үед үнэлэх, давтан үнэлэх, гол зовиур түүнд авсан арга хэмжээ эмчилгээ, үйлчилгээний динамик өөрчлөлтийг хянах ба ажиглах чадварт суралцах. Эмчилгээ үйлчилгээнд гарч болох ноцтой алдааг таамаглах алдааг засах чадварт суралцах;
- Амь тэнссэн салбарын болон бусад салбарын мэргэжилтэнтэй мэргэжлийн үүднээс зөвлөлдөн баг болон ажиллаж өвчтөний эмчилгээ үйлчилгээг Монгол улсын стандарт дүрэм журмын дагуу гүйцэтгэх;
- Өвчтөнг эмнэлэгт хэвтүүлэх, яаралтай тусламжийн тасгийн ажиглалтын өрөө, эрэмбийн хэсэг зэрэг хяналтын түвшин адилгүй талбарт өвчтөнг эрэмбэлэн хувиарлах, эмнэлгээс (ЯТТ-аас) өвчтөнг гаргах (эмчилгээ бичих, дараагийн үзлэгийн цаг болон нарийн мэргэжлийн эмчийн үзлэг төлөвлөлт), эмнэлгийн бусад тасагт шилжин хэвтэх, бусад эмнэлэгт шилжүүлэх үйл ажиллагаанд ар гэр болон эмнэлгийн бусад мэргэжилтэнтэй хамтран үр дүнтэй ажиллах;
- Халдварт өвчин түүний дэгдэлтийн үед урьдчилан сэргийлэх, тусгаарлах аргад суралцан иргэд болон эмнэлгийн ажилтанд мэдээлэл өгөх, тусгаарлах сэргийлэх ажлыг зохион байгуулах чадварт суралцах. Зарим урьдчилан сэргийлж болохуйц өвчин, гэмтэл зэргээс сэргийлэх аргачлалыг иргэдэд зааварчлах чадварт суралцах;
- Эмнэлгийн цахим мэдээллийн системийг чадварлаг ашиглаж сурах. Анхан шатны бичиг баримт хөтлөлтийг товч тодорхой, ойлгомжтой, анхан шатны баримт бичиг хөтлөлтийг журмын дагуу хөтлөх бөгөөд эмнэлгийн бусад ажилтан ашиглах боломжтой байх;

**Суралцагч *(Learner):***

- Өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтад тасралтгүй хамрагдаж өөрийгөө хөгжүүлдэг байх;
- Өдөр бүр шинэчлэгдэж байгаа анагаах ухааны мэдлэгийг олж авахын тулд өөрийн санаачлагаар төрөл бүрийн мэдээллийн сангаас хайлт хийж, олон мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй сайжруулах;

**Харилцагч *(Communicator):***

- Амь тэнссэн байдалд байгаа өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцан ойлгуулах чадвартай болох;

- Шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх, харилцан санал солилцох;
- Өвчтөн болон түүний ар гэрийн хүсэлтийг сайн сонсож өвчний шалтгаан, явц тавилан, цаашдын баримтлах дэглэмийн талаар ойлгомжтой энгийн үг хэллэг ашиглан тайлбарлаж ойлгуулах;

**Хамтрагч *(Collaborator)*:**

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллагч байх;
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллахад суралцах;
- Мэргэжлийн нийгэмлэг холбооны (Монголын яаралтай тусламжийн нийгэмлэг) үйл ажиллагаанд хамтран оролцож өөрийн болон бусдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх үйл ажиллагаанд хамтрагч байж санал бодлоо илэрхийлж ажиллах;

**Эрүүл мэндийн зөвлөгч *(Community Health Advocator)*:**

- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх аргад сурах;
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон нийгэмд чиглэсэн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож эрүүл мэндийн зөвлөгч байх;
- Хүн амын эрүүл мэндийн суурь боловсрол, амилуулах суурь тусламж, анхны тусламжийн боловсролыг олгох сургагч багш, мэргэжилтэн байх;
- Үй олныг хамарсан осол, гэмтлийн үед хүн амьд зориулан ухуулан сурталчлах, заан зөвлөх, сургах, зөв зохион байгуулах чадвартай байх;

**Зохион байгуулагч, манлайлагч *(Leader):***

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээн дээр манлайлан ажиллах үүргээ ухамсарлан ажиллах;
- Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах;
- Мэргэжил нэгт нөхдөө манлайлан чиглүүлж, тэдэнд урам өгч, нэгэн зорилгын төлөө нэгтгэж чаддаг байх;
- Нийгэмд тустай үйл ажиллагааг зохион байгуулахад манлайлан оролцогч байх;
- Улсын хэмжээнд зохион байгуулах шаардлагатай өөрийн мэргэшлийн чиглэлийн үйл ажиллагаанд манлайлагч нь байх;

## ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ:

**5.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил:**

Сургалт нь ажлын байрны сургалт (On the job), танхимын болон дууриамал орчин дахь сургалт (Off the job, SD), идэвхтэй, идэвхгүй хэлбэрээр явуулна.

- Яаралтай тусламж судлал үндсэн мэргэшлийн сургалт нь 17 тойролтоор явагдах бөгөөд эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, амилуулах суурь тусламж, халдварын сэргийлэлт, хяналтын сургалтанд заавал хамрагдана.
- Сургалтын хугацаа 2 жил байна.
- Сургалт эрхлэх үндсэн байгууллага нь яаралтай тусламжийн эмч бэлтгэх энэхүү сургалтын эрх авсан эмнэлэг болох Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Монгол-Японы сургалтын эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг байна.
- Мэргэжлийн онцлог болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээс шалтгаалан дараах “сүлжээ” эмнэлгүүдийг болгон сонгон авч тойролт хийх байгууллага нь Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн түргэн тусламжийн төв болон Нийслэлийн онцгой байдлын газрын харъяа гамшгаас хамгаалах сургалтын төвтэй сургалтын гэрээ хийж ажиллана.
- Сургалт эрхлэх үндсэн байгууллага болон сүлжээ эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг, эрчимт эмчилгээний тасаг, хагалгааны өрөө, сэрээх өрөө, эмнэлзүйн ур чадварын өрөө, сургалтын өрөө, түргэн тусламжийн автомашинуудад явагдана.

**5.2 Зайлшгүй эзэмших хам шинж, шинж тэмдэг, *(signs and symptoms)* гардан үйлдэл** (бүх чиглэлээр нийтлэг):

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялган оношилгоо хийн, анхан шатны эмчилгээг эхлүүлж чаддаг болох:

**Зайлшгүй эзэмших 26 шинж тэмдэг, хам шинж *(signs and symptoms)*:**

1. Амьсгал, цусны эргэлтийн зогсолт / Cardiac Arrest /
2. Ухаан алдалт, баларталт / Convulsions, Syncope/
3. Оворго / Coma /
4. Шок /Shock/
5. Амьсгаадалт / Shortness of breath/
6. Цээжээр өвдөлт /Chest pain/

7. Аминд осолтой зүрхний хэм алдагдалт / Life threatening Arrhythmia/
8. Хэвлийн цочмог өвдөлт /Acute abdominal pain /
9. Цус алдалт / Bleeding /Life-threatening
10. Цустай бөөлжилт / Vomiting blood /
11. Шингэн алдалт / Dehydratase /
12. Таталт / Seizures/
13. Мөчдийн саажилт /Limb Paralysis /
14. Халуурлалт / Fever /
15. Шарлалт, шарлах хам шинж /Jaundice /
16. Толгой өвдөлт /Headache /
17. Ханиалгалт, цэр гаралт (цустай,  идээрхэг, салсархаг) /Cough, sputum/
18. Цустай өтгөн, цустай гүйлгэлт / Bloody stool, bloody diarrhea /
19. Дотор муухайралт, бөөлжилт / Nausea, vomit /
20. Суулгалт / Diarrhea /
21. Сэтгэл гутрал / Depression /
22. Хавагнах / Oedema /
23. Анафилакси / Anaphylaxis /
24. Тууралтын хам шинж / Syndrome
25. Манас таталтын хам шинж / Eclampsia /
26. Хордлогын хам шинж / Poison syndrome/

**5.3 Гардан үйлдэл:**

**Зайлшгүй хийж сурах 34 гардан үйлдэл:**

1. Яаралтай тусламжийн эрэмбэлэлт
2. Яаралтай тусламжийн анхан шатны бичиг баримт хөтөлж сурах
3. Яаралтай тусламжийн үеийн багаж, тоног төхөөрөмж бэлтгэх
4. Яаралтай тусламжийн тасагт ашиглах тоног төхөөрөмж дээр ажиллах
5. Амь тэнссэн өвчтөнд анхдагч үнэлгээ хийж, тусламж үзүүлэх /General physical examination – 89.7/
6. Амь тэнссэн өвчтөнд лавшруулсан үнэлгээ хийж тусламж үзүүлэх
7. Дефибрилляторыг ажиллуулах, өвчтөнд хэрэглэх аргачлал /Other electric countershock of heart – 99.62/
8. Зүрхний шууд бус массаж /Closed chest cardiac massage – 99.63/
9. Амьсгалын зам чөлөөлөх хэрэгслийг хэрэглэх /Nonoperative intubation of gastrointestinal and respiratory tracts – 96.0/
10. Амьсгалуулах хэрэгслүүдтэй ажиллаж амьсгал өгөх /Nonmechanical methods of resuscitation – 93.93/
11. Хэт авиан эмчилгээ /Therapeutic ultrasound – 00.0/

12. Захын венийн судсанд гуурс тавих
13. Төвийн венийн судсанд гуурс тавих
14. Үнхэлцэгт хатгалт хийх /Pericardiocentesis – 37.0/
15. Амилуулах суурь, лавшруулсан тусламж үзүүлэх /Cardiopulmonary resuscitation, not otherwise specified – 99.60/
16. Механик амьсгалын аппараттай ажиллах /Other continuous mechanical ventilation – 96.7/
17. Өвчтөний хяналтын монитортой ажиллах
18. Даралтат хийн системтэй ажиллах аргачлал
19. Хүнд өвчтөнийг эмнэлэг дотор аюулгүй зөөвөрлөх
20. Тээврийн хэрэгслээр хүнд өвчтөн тээвэрлэх
21. Цээжний хөндийн хатгалт хийх /Thoracentesis – 34.91/
22. Булчин ясны болон арьс бүрхүүлийн тогтолцоонд мэс заслын бус аргаар оруулалт хийх, чиг тавих /Nonoperative replacement of musculoskeletal and integumentary system appliance – 97.1/
23. Давсагт шээлгүүр байрлуулах /Percutaneous cystostomy – 57.17/
24. Зүрхний цахилгаан бичлэг хийх /Electrocardiogram – 89.52/
25. Захын цусны глюкоз тодорхойлох
26. Тархи нугасны шингэн шинжлэх зорилгоор бүсэлхийн хатгалт хийх
27. Ходоодонд хаймсуур тавих /Replacement of (naso-) gastric or esophagostomy tube – 97.01/
28. Хэвлийн хөндийн хатгалт хийх
29. Нуруу нугасны гэмтэлтэй өвчтөний бэхэлгээ хийх /Replacement of other cast – 97.13/
30. Дээд мөчдөд чиг тавьж бэхлэх /Replacement of cast on upper limb – 97.11/
31. Доод мөчдөд чиг тавьж бэхлэх /Replacement of cast on lower limb – 97.12/
32. Цус тогтоох аргуудыг эзэмших (чангалуур, даралтад болон цус тогтоох боолт)
33. Цусны бүлэг тодорхойлох, цус сэлбэх
34. Тусгаарлалт /Isolation – 99.84/

**Сургалтын ерөнхий төлөвлөгөө**

1. **Ажлын байрны сургалт (On-the Job Training)**

| Аргачлал | Суралцагч эмчийн тоо | Үргэлжлэх цаг, давтамж | Үргэлжлэх хугацаа | Сургалт явагдах газар | Хэрэглэгдэ-хүүн | Удирдагч, хамтрагч |
|---|---|---|---|---|---|---|
| Эрэмбийн үзлэг | 4 | Өдөр бүр 09-16 цагийн хооронд | Нэгдүгээр дамжааны туршид | Яаралтай тусламжийн тасгийн эрэмбэлэх | Үйлчлүүлэгч | Эмнэлзүйн чиглүүлэгч, сургагч багш, тасгийн эмч |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 5-аас доошгүй | | хэсэгт | | нар, эрэмбэлэх сувилагч |
| Онош тодруулах, үзлэг оношилгоо хийх | 4 | Өдөр бүр 09-16 цагийн хооронд 3-аас доошгүй | Нэг, хоёрдугаар дамжааны туршид | Яаралтай тусламжийн тасгийн хяналт эмчилгээний хэсэгт | Үйлчлүүлэгч | Эмнэлзүйн чиглүүлэгч, сургагч багш, тасгийн эмч нар, нарийн мэргэшлийн эмч, сувилагч |
| Ганцаарчилсан тойрон үзлэг хийх | 4 | Өдөр бүр 2 цаг | Нэг, хоёрдугаар дамжааны туршид | Яаралтай тусламжийн тасагт | Үйлчлүүлэгч | Суралцагч, хамтран суралцагц, сувилагч |
| Амилуулах тусламжид оролцох | 4 | Тохиодол гарсан үед | Нэг, хоёрдугаар дамжааны туршид | Амилуулах тусламжийн өрөө | Үйлчлүүлэгч | Эмнэлзүйн чиглүүлэгч, сургагч багш, бусад эмч сувилагч нар |
| Гардан үйлдэл хийх | 4 | Тохиодол гарсан үед | Нэг, хоёрдугаар дамжааны туршид | Яаралтай тусламжийн тасаг | Үйлчлүүлэгч | Эмнэлзүйн чиглүүлэгч, сургагч багш, бусад эмч нар |
| Бичил мэс ажилбарт оролцох | 4 | Өдөрт 1 удаа | Нэгдүгээр дамжааны турш | Мэс заслын өрөө | Үйлчлүүлэгч | Эмнэлзүйн чиглүүлэгч, сургагч багш, |
| Орны дэргэдэх тойрон үзлэг | 4 | Ажлын өдрүүдэд 08.30-09.00 цагийн хооронд | Нэг, хоёрдугаар дамжааны туршид | Яаралтай тусламжийн тасгийн хяналт эмчилгээний болон тусгаарлах хэсэг | Үйлчлүүлэгч | Эмнэлзүйн чиглүүлэгч, сургагч багш, тасгийн эмч нар, нарийн мэргэшлийн эмч, сувилагч |

## 2. Танхимын сургалт (Off-the Job Training)

| Аргачлал | Суралцагч эмчийн тоо | Үргэлжлэх цаг, давтамж | Сургалт явагдах газар | Үйлчлүүлэгч/ Хэрэглэгдэхүүн | Удирдагч, хамтрагч |
|---|---|---|---|---|---|
| Бие даалт | 1 | Тохиромжтой, чөлөөт цаг | Гэртээ, номын сан | Ном, интернет | Өөрөө, хамтран суралцагч |
| Лекц | 20 хүртэл | 7 хоногт 2-3 удаа 2 цаг | Хичээлийн өрөө | Слайд, проектор | Эмнэлзүйн чиглүүлэгч, сургагч багш, хамтран суралцагч |
| Журнал клуб | 20 хүртэл | 7 хоногт 1 удаа | Хичээлийн | Слайд, э.ш-ний | Эмнэлзүйн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2 цаг | өрөө | өгүүлэл | чиглүүлэгч, сургагч багш, хамтран суралцагч |
| Дууараймал орчин | 5 хүртэл | 7 хоногт 1 удаа 2 цаг | Дадлагажуулах өрөө | Хамтран суралцагч, манекин | Эмнэлзүйн чиглүүлэгч, сургагч багш, |
| Судалгааны ажил хийх | 1 | Жилд нэг удаа | Номын сан, сургалтын танхим | Ном, интернет | Эмнэлзүйн чиглүүлэгч, сургагч багш, хамтран суралцагч, Өөрөө |

## 3. Үйл ажиллагааны хуваарь

| Хугацаа | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан |
|---|---|---|---|---|---|
| 08:00 – 09:00 | | | Резидент эмч нарын яриа | | Эмч нарын яриа |
| 08:20 – 08:40 | Ээлж хүлээлцэх | Ээлж хүлээлцэх | Ээлж хүлээлцэх | Ээлж хүлээлцэх | Ээлж хүлээлцэх |
| 08:40 – 08:50 | Орны дэргэдэх тойрон үзлэг | Орны дэргэдэх тойрон үзлэг | Орны дэргэдэх тойрон үзлэг | Орны дэргэдэх тойрон үзлэг | Орны дэргэдэх тойрон үзлэг |
| 08:50 – 16:20 | Яаралтай тусламжийн тасагт ажиллах | Яаралтай тусламжийн тасагт ажиллах | Яаралтай тусламжийн тасагт ажиллах | Яаралтай тусламжийн тасагт ажиллах | Яаралтай тусламжийн тасагт ажиллах |
| 13.00 – 15.00 | Лекц | Бие даалт | Лекц | Бие даалт | Журнал клуб |
| 16:20 – 08:20 | Оройн ээлжийн ажлыг цаг | Оройн ээлжийн ажлыг цаг | Оройн ээлжийн ажлыг цаг | Оройн ээлжийн ажлыг цаг | Оройн ээлжийн ажлыг цаг |
| 14:00 – 15:00 | Орчуулгын лекц | Гардын үйлдлийн хичээл болон шалгалт | 2 дугаар дамжааны резидент эмч нарын лекц | Бусад тасгийн эмч нарын лекц | Орчуулгын лекц |

## ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА:

### Тойролтын хуваарь

| № | Тойролт | Долоо хоног | Улирал | Сургалт зохион байгуулах эмнэлэг |
|---|---|---|---|---|
| 1 | Яаралтай тусламжийн үндэс | 17 | I, II, IV | Сургалт эрхлэх байгууллага |
| 2 | Амь тэнссэн үеийн яаралтай тусламж | 5 | I, III, IV | Сургалт эрхлэх байгууллага |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Эрчимт эмчилгээний тусламж | 4 | I, III | Сургалт эрхлэх байгууллага |
| 4 | Дотрын өвчний яаралтай тусламж | 5 | II, III | Сургалт эрхлэх байгууллага |
| 5 | Мэс заслын цочмог өвчнүүдийн үед үзүүлэх яаралтай тусламж | 5 | I, III | Сургалт эрхлэх байгууллага |
| 6 | Гэмтэгсдийг аврах лавшруулсан тусламж | 5 | I, III, IV | Монголын яаралтай тусламжийн нийгэмлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв |
| 7 | Мэдрэлийн эрхтэн тогтолцооны яаралтай тусламж | 4 | III, IV | Сургалт эрхлэх байгууллага |
| 8 | Хүүхдийн яаралтай тусламж | 10 | I, II, IV | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв |
| 9 | Эх барих эмэгтэйчүүдийн өвчний үеийн яаралтай тусламж | 4 | III, IV | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв |
| 10 | Хүрээлэн буй орчны нөлөөт гэмтлүүдийн үед үзүүлэх яаралтай тусламж | 4 | II, III | Монголын яаралтай тусламжийн нийгэмлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв |
| 11 | Сэтгэц, зан үйлийн зарим эмгэгийн яаралтай тусламж | 2 | IV | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв |
| 12 | Цочмог хордлогын яаралтай тусламж | 2 | IV | Цэргийн Төв Эмнэлэг |
| 13 | Халдварт өвчний яаралтай тусламж | 3 | II, III | Халдварт өвчин судлалын үндэсний төв |
| 14 | Яаралтай тусламжийн дүрс оношилгоо | 5 | II, III | Сургалт эрхлэх байгууллага |
| 15 | Гамшиг, онцгой байдлын үеийн тусламж үйлчилгээ, зохион байгуулалт, хүнд өвчтөний тээвэрлэлт | 2 | IV | Нийслэлийн онцгой байдлын газрын харъяа гамшгаас хамгаалах сургалтын төв |
| 16 | Яаралтай тусламжийн үеийн мэдээгүйжүүлэг, тайвшруулалт, өвдөлт намдаалт | 4 | I | Сургалт эрхлэх байгууллага |
| 17 | Эмнэлэг хүртлэх яаралтай тусламж | 7 | I, IV | Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг, Нийслэлийн түргэн тусламжийн төв |
| | Нийт багц цаг | 88 | | |

**ТОЙРОЛТЫН АГУУЛГА**

**Тойролт 1. Яаралтай тусламжийн онол, арга зүйн үндэс:**

- Амин чухал эрхтнүүдийн физиологи:
    - Зүрх судасны физиологи
    - Амьсгалын физиологи
    - Хүчилтөрөгчийн хангамжийн физиологи
    - Хийн солилцооны физиологи
    - Тархины цусан хангамжийн физиологи
    - Ургал мэдрэлийн ф изиологи
    - Эрдэс усны солилцоо, тэнцвэр
    - Дотоод шүүрлийн эрхтний физиологи
    - Бөөрний физиологи
    - Элэгний физиологи
    - Өвдөлтийн физиологи
    - Жирэмсний физиологи
- Эмнэлгийн яаралтай тусламжид хэрэглэгдэх эмүүд:
    - Фармакологийн үндэс, эмийн тунг тооцоолох;
    - Эмийн фармакокинетик;
    - Фармакодинамик ба авуурын физиологи;
    - Ургал мэдрэлийн фармакологи;
    - Амь тэнссэн үед хэрэглэх эмүүд;
    - Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих эмүүд;
    - Мансууруулах бодисын фармакологи;
    - Өвдөлт намдаах эмийн фармакологи;
- Яаралтай тусламжид хэрэглэгддэг тоног төхөөрөмжийн физик үндэс болон аюулгүй ажиллагааны заавар:
    - Даралтат хийн системтэй ажиллах;
    - Шахсан хийн бортоготой ажиллах;
    - Даралт тохируулагч хавхлагатай \редуктор\ ажиллах;
    - Биологийн үзүүлэлтийг хэмжих, мэдээлэх “си” системтэй ажиллах;
    - Цэнэгжилт, туйлшрал, гал, дэлбэрэлтийн тухай;
    - Дулаан солилцооны физиологи;
    - Хийн солилцооны үзүүлэлтүүд, хэмжилт;
    - Амьсгалын аппаратын бүтэц зохион байгуулалт;
    - Амьсгалын хүрээний төрлүүд;
    - Хяналтын монитортой ажиллах (АД, зүрхний цохилтын тоо, захын цусны сатураци, биеийн халуун, амьсгалын тоо);

- Пульсоксиметр;
- Капнометр;
- Дефибрилляторын аюулгүй ажиллагаа;
- Гадна тохируулгат дефибриллятор;
- Чийглэгч, утлага, абсорбер;
- Гадна пейсмекерийг ажиллуулах зарчим;
- Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат;
- Зөөврийн рентген аппараттай ажиллах;
- Цусны глюкоз хэмжигчтэй ажиллах;
- Цусны гемоглобин тодорхойлох аппараттай ажиллах;
- Дусал тохируулагчтай ажиллаж сурах;
- Автомат тариурыг ажиллуулах;
- Яаралтай тусламжийн зориулалтаар тоноглосон тээврийн хэрэгсэлтэй ажиллах;

- Эмнэлгийн яаралтай тусламжийн бүтэц зохион байгуулалтын онол арга зүйн үндсийг эзэмших:
  - Эмнэлгийн яаралтай тусламжийн онол арга зүйн үндэс, эрэмбэлэн ялгалт;
  - Эмнэлэг хүртэлх болон эмнэлэг доторх яаралтай тусламжийн онол арга зүйн үндэс;
  - Яаралтай тусламжийн тасгийн бүтэц зохион байгуулалт
  - Гамшиг онцгой байдлын үеийн тусламж үйлчилгээ, зохион байгуулалт;
  - Эмнэлгийн яаралтай тусламжийн үеийн хууль эрх зүйн нь болон ёс зүйн үндэс;

**Тойролт 2. Амь тэнссэн үеийн яаралтай тусламж:**

- Амилуулах суурь тусламж;
  - Ухаангүй өвчтөнг үнэлэх;
  - Аюул ослыг зайлуулах;
  - Цээж шахалт хийх;
  - Амьсгалын зам чөлөөлөх энгийн арга;
  - Амьсгалуулах хялбар аргууд;
  - Гадна тохируулгат дефибрилляторыг хэрэглэх;
  - Амилуулах суурь тусламжийг багаар үзүүлэх;
- Амилуулах лавшруулсан тусламж;
  - Ухаангүй өвчтөнийг үнэлгээ;
  - Амьсгалын зам чөлөөлөх лавшруулсан аргууд;

- Амьсгалуулах лавшруулсан аргууд;
- Цээж шахалт хийх;
- Гар ажиллагаат дефибрилляторыг хэрэглэх;
- Амилуулах лавшруулсан тусламжийг багаар үзүүлэх;

- Зүрх эргэн сэргэсний дараах эмчилгээ;
- Амьсгал, зүрх судас зогсох үндсэн шалтгаануудыг ирүүлэх;
- Амьсгалын замын бөглөрлийн яаралтай тусламж;
- Аспирацийн үед яаралтай тусламж үзүүлэх нь;
- Аминд халтай хэм алдалтуудын үед авах арга хэмжээ;
- Комын үеийн яаралтай тусламж;
- Амь тэнссэн эмгэгүүдийн яаралтай тусламж;

**Тойролт 3. Эрчимт эмчилгээний тусламж:**

- Эрчимт эмчилгээнд ашиглагдах бичиг баримт хөтлөлт
- Хүнд өвчтөний хяналт үнэлгээ;
- Амьсгалын дутагдалын үеийн эрчимт эмчилгээ;
- Зүрх судасны тогтолцооны эрчимт эмчилгээний тусламж;
- Хүчилтөрөгч эмчилгээний физиологийн үндэс, эмчилгээний зарчим;
- Амьсгалын аппаратын үйл ажиллагаа, төрөл, хэрхэн ашиглах;
- Шоктой өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;
    - Зүрхний гаралтай;
    - Зүрхний бус гаралтай;
    - Хувиарлалтын;
    - Эзэлхүүн багадалтын;

**Тойролт 4. Дотрын өвчний яаралтай тусламж:**

- Дотрын өвчний онош зүй
- Зүрхний цахилгаан бичлэгийн түргэвчилсэн үнэлгээ;
- Амьсгаадах үед үзүүлэх яаралтай тусламж;
- Цээжээр гэнэт хүчтэй өвдөх үед үзүүлэх яаралтай тусламж;
- Хэвлийн өвдөлтийн ялган оношлогоо, авах арга хэмжээ;
- Амьсгалын цочмог дутмагшилын хэлбэр, авах арга хэмжээ;
    - Амьсгалын замын бөглөрлийн яаралтай тусламж;
    - Аспирацийн үе дэх яаралтай тусламж;
    - Гуурсан хоолойн багтраа авах арга хэмжээ;
- Зүрх судасны цочмог дутмагшилын хэлбэр, авах арга хэмжээ;
    - Зүрхний хурц шигдээс, зүрхний гаралтай шок;
    - Зүрхний хүнд хэлбэрийн хэм алдагдал, арга хэмжээ;

- Уушгины артерийн тромбоэмболи;
- Уушгины хаван, түүнтэй тэмцэх;
- Гипертонийн криз, яаралтай тусламж;
- Зүрхэнд сэдээгч болон дефибрилляци хийх техник;

- Шоктой өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;
  - Зүрхний гаралтай;
  - Зүрхний бус гаралтай;
  - Хувиарлалтын;
  - Ээлхүүн багадалтын;
- Дотрын өвчнүүдийн ялган оношилгоо, яаралтай тусламж;
  - Бөөрний цочмог дутмагшил, яаралтай авах арга хэмжээ;
  - Элэгний цочмог дутмагшил, яаралтай авах арга хэмжээ;
  - Хоол боловсруулах замын цус алдалтын яаралтай тусламж;
  - Хэвлийн хөндийд шингэн хуралдах, ялган оношилгоо;
  - Цээжний хөндийд шингэн хуралдах, ялган оношилгоо;
  - Үнхэлцэг хальсанд шингэн хуралдах, ялган оношилгоо;
- Дотоод шүүрлийн эрхтний дутмагшил, авах арга хэмжээ;
  - Бамбайн хордлого (тиреотоксикоз);
  - Чихрийн шижингийн комууд;
  - Бөөрний дээд булчирхайн эмгэгүүд;

**Тойролт 5. Мэс заслын цочмог өвчнүүдийн үед үзүүлэх яаралтай тусламж:**

- Хөндийт эрхтэн цоорох өвчнүүд, ялган оношилгоо;
- Мухар олгойн цочмог үрэвсэл;
- Нойр булчирхайн цочмог үрэвсэл;
- Цөсний хүүдийн цочмог үрэвсэл;
- Гэдэсний түгжрэл;
- Хатиг булаа нээх;
- Үгдэрсэн үжлын үед үзүүлэх тусламж;

**Тойролт 6. Гэмтэгсдийг аврах лавшруулсан тусламж:**

- Гэмтэгсдийг үнэлэх үнэлгээ /ABCDE/;
- Талбар дээрх эрэмбэлэн ангилалт;
- Цочмог цус алдалтын үед үзүүлэх яаралтай тусламж;
  - Цус алдалтын үед үзүүлэх анхны тусламж;
  - Гэмтлийн цус алдалтын яаралтай тусламж;
  - Урт мөчдийн  цус алдалтыг тогтоох;
- Шархны анхдагч цэгцэлгээ хийх;

- Боолт, боолтын арга зүй;
- Гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;
  - Гэмтэлтэй өвчтөнийг үнэлэх;
  - Үндсэн амилуулах тусламж үзүүлэх;
  - Цээжний гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;
  - Хэвлийн гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;
  - Нугасны гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;
  - Тархины гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;
  - Мөчдийн гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;
  - Хэвлийн гэмтэлтэй өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;
- Хүзүү болон нуруу нугасны гэмтэлтэй өвчтөнд бэхэлгээ хийх
- Хүүхдийн гэмтлийн үеийн яаралтай тусламж
- Гэмтэлтэй хүнд өвчтөнг тээвэрлэх;

**Тойролт 7. Мэдрэлийн эрхтэн тогтолцооны яаралтай тусламж:**

- Тархины цус харвалтууд;
- Булчин сулрах эмгэгүүд;
- Энцефалитууд;
- Гипоксийн энцефалопати;
- Менингитүүд;
- Уналт таталтын хам шинжийн үеийн яаралтай тусламж;
- Тархины хаван;
- Комын оношилгоо, эмчилгээ, яаралтай тусламж;
- Бодисын солилцооны ком;
- Тархины бүтцийн шалтгаантай ком;

**Тойролт 8. Хүүхдийн яаралтай тусламж**

- Нялхасын амилуулах суурь болон лавшруулсан тусламжийн онцлог
- Хүүхдийн амилуулах суурь болон лавшруулсан тусламж
- Хүүхдийн эрэмбэлэн ангилалт
- Шокийн үед авах яаралтай тусламж
- Оврогын үед авах яаралтай тусламж
- Хүүхдийн яаралтай тусламжинд хэрэглэгдэх эм тариа, түүний тунг тооцоолох
- Хүүхдийн хордлогын үеийн яаралтай тусламж
- Тахикарди
- Брадикарди
- Хүүхдийн таталтын үеийн яаралтай тусламж

- Нялхас болон хүүхдийн хахалтын үед авах яаралтай тусламж
- Төвөнхийн бачуурал
- Хүүхдийн анафилаксийн үеийн яаралтай тусламж
- Хүүхдийн хэвлийн цочмог өвдөлтийн үеийн яаралтай тусламж
- Гипергликеми болон гипогликемийн үеийн яаралтай тусламж

**Тойролт 9. Эх барих эмэгтэйчүүдийн өвчний үеийн яаралтай тусламж:**

- Жирэмсний үеийн амилуулах тусламж;
- Нярайн амилуулах тусламж /төрөх өрөөн доторх, төрөх өрөөний гаднах/;
- Манас таталтын (Преэклампси, эклампси) үед үзүүлэх яаралтай тусламж;
- HELLP хамшинж;
- Жирэмсний эхний 3 сарын үеийн яаралтай тусламж шаардагдах эмгэгүүд;
- Жирэмсний дунд 3 сарын үеийн яаралтай тусламж шаардагдах эмгэгүүд;
- Жирэмсний сүүлийн 3 сарын үеийн яаралтай тусламж шаардагдах эмгэгүүд;
- Төрөлтийн яаралтай тусламж шаардагдах эмгэгүүд;
- Эмэгтэйчүүдийн цус алдалтын үеийн яаралтай тусламж;

**Тойролт 10. Хүрээлэн буй орчны нөлөөт гэмтлүүдийн үед үзүүлэх яаралтай тусламж:**

- Хордлогын үед үзүүлэх яаралтай тусламж;
- Дулаанд цохиулах үед үзүүлэх яаралтай тусламж;
- Цахилгаан, туяанд цохиулах үед үзүүлэх яаралтай тусламж;
- Усанд живсэн хүнд  үзүүлэх яаралтай тусламж;
- Түлэгдлийн үед үзүүлэх яаралтай тусламж;
- Осголтын үед үзүүлэх яаралтай тусламж;
- Хөлдөлтийн үед үзүүлэх яаралтай тусламж;

**Тойролт 11. Сэтгэц, зан үйлийн зарим эмгэгийн яаралтай тусламж:**

- Сэтгэцийн эмгэгийн үеийн албадан эмчилгээ;
- Дистони хариу урвал;
- Мюнхаузены хам шинж;
- Цочмог солиорох эмгэг;
- Ухаан дэмийрэн балартах
- Хүчирхийллийн үед үзүүлэх яаралтай тусламж;
- Уналт таталтын үед үзүүлэх яаралтай тусламж;
- Сэтгэл цочирдох эмгэг;
- Амиа хорлох эрсдэл;
- Сандрах дайрлага;

**Тойролт 12. Цочмог хордлогын яаралтай тусламж:**

- Цочмог хордлогын үед авах ерөнхий арга хэмжээ;
- Сэтгэц нөлөөт, мансууруулах эмийн бодисын хордлогууд, хэлбэр, менежмент, хоргүйсүүрийн хэрэглээ;
- Үрэвслийн эсрэг стройд болон стройд бус эмийн бодисын хордлогууд, хэлбэр, менежмент, хоргүйсүүрийн хэрэглээ;
- Уналт, таталтын эсрэг эмийн бодисын хордлогууд, хэлбэр, менежмент, хоргүйсүүрийн хэрэглээ ;
- Өргөн хэрэглэгддэг зүрх судсанд нөлөөт эмийн бодисын хордлогууд, хэлбэр, менежмент, хоргүйсүүрийн хэрэглээ;
- Хүнд металлын хордлогууд, хэлбэр, менежмент, хоргүйсүүрийн хэрэглээ;
- Ахуйн хэрэглээний ариутгал, цэвэрлэгээний химийн бодисын хордлогуудын тусламж үйлчилгээ;
- Ахуйн хэрэглээний шавьж мэрэгч устгалын химийн бодисын хордлогуудын тусламж үйлчилгээ;
- Спирт, спиртэн төрлийн химийн бодисын хордлогууд, хэлбэр, менежмент, хоргүйсүүрийн хэрэглээ;
- Нүүрсхүчлийн дутуу исэлийн /угаар/ хий болон бусад хийн хордлогууд, хэлбэр, менежмент, хоргүйсүүрийн хэрэглээ;
- Шатах, тослох химийн хордлогууд, хэлбэр, менежмент, хоргүйсүүрийн хэрэглээ;

**Тойролт 13. Халдварт өвчний яаралтай тусламж:**

- Халдварын сэргийлэлт хяналт;
- Яаралтай тусламжийн үеийн дотоод халдвар, урьдчилан сэргийлэлт, тусгаарлалт халдвар хамгааллын дэглэм;
- Шинэ болон сэргэж буй халдварт өвчний үед авах арга хэмжээ, зохион байгуулалт;
- Халдвар-хордлогын шок, шинэ тэмдэг, оношилгоо, яаралтай тусламж;
- Вирусын хүнд халдварын үеийн яаралтай тусламж;
- Зоонозын гаралтай халдварын үеийн яаралтай тусламж;
- ХДХВ/ДОХ-ын халдвартай өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж;

**Тойролт 14. Яаралтай тусламжийн дүрс оношилгоо:**

- Яаралтай тусламжийн үеийн рентген оношилгоо;
- Компьютер томографийн шинжилгээг унших аргачлал;
- Соронзон резононст томографийн шинжилгээг унших аргачлал;
- Яаралтай тусламжийн үеийн хэт авиан оношилгоо (POCUS);
- Яаралтай тусламжийн үеийн зүрхний болон мэдрэл судсан дотуурх оношилгоо, эмчилгээ;

**Тойролт 15. Гамшиг, онцгой байдлын үеийн тусламж үйлчилгээ, зохион байгуулалт, хүнд өвчтөний тээвэрлэлт:**

- Гамшгийн онцгой байдлын үеийн зохион байгуулалт;
- Гамшгийн онцгой байдлын төлөвлөгөө, эрсдэлийн менежмент;
- Гамшгийн голомтод ажиллах журам;
- Нөхцөл байдалд үнэлгээ өгөх;
- Талбар дээрх эрэмбэлэн ангиалалт;
- Ослын талбар дээр үзүүлэх яаралтай тусламж;
- Тээвэрлэлт, харилцаа холбоо;
- Гамшгийн үеийн сэтгэл зүйн тусламж;
- Хүнд өвчтөний анхны тусламж, үнэлгээ;
- Хүнд өвчтөнийг тогтворжуулах;
- Тээвэрлэлтийн нөхцөл, бэлтгэл;
- Эмнэлэг хүртэлх, эмнэлэг хооронд өвчтөн тээвэрлэх журам;

**Тойролт 16. Яаралтай тусламжийн үеийн мэдээгүйжүүлэг, тайвшруулалт, өвдөлт намдаалт:**

- Өвдөлт намдаалт;
- Ажилбарын өмнөх тайвшруулалт;
- Хэсгийн мэдээгүйжүүлэг хийх аргууд;
- Мэдээгүйжүүлгийн эмийн төрлүүд, бодисууд;

**Тойролт 17. Эмнэлэг хүртлэх яаралтай тусламж:**

- Түргэн тусламжийн автомашинд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийг ашиглах;
- Ухаангүй өвчтөнг үнэлэх, яаралтай тусламж үзүүлэх;
- Зонхилон тохиолдох эмгэгүүдийн үед үзүүлэх яаралтай тусламж;
- Тээвэрлэлтийн төрлүүд;
- Агаарын татан гаргалт;
- Яаралтай тусламжийн цүнхэнд байх эм эмнэлгийн хэрэгсэлийг ашиглах;
- Өвчтөн түүний ар гэрийнхэнд зөвөлгөө өгөх;

## ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ:

### 7.1 Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрт хэрхэн ахиж дэвшиж байгаа хэрхэн сайжруулах боломжтой талаар эргэн зөвөлгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (*career plan*) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн (mentor) цаашид “хариуцагч”-ийг оноож хувиарлана. Суралцагч эмч

нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид сар тутамд 1-2 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэйгээ танилцаж, эргэн зөвлөгөө авна.

### 7.2 Суралцагч эмч ба эмнэлзүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэлзүйн сургагч багшийг оноож хувиарлана.

- Суралцагч эмч бүр тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэлзүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтондоо хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэлзүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тухайн тойролт дуусахад эмнэлзүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар зөвлөгөө авна.

### 7.3 Үнэлгээний арга

#### 7.3.1 Төгсөлтийн шалгалт

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулах "Яаралтай тусламж судлал"-ын сургалтын төгсөлтийн шалгалтыг өгнө. Шалгалтанд тэнцсэн тохиолдолд гардан үйлдэлийн шалгалт өгч 80 ба түүнээс дээш хувийн үнэлгээ авсан тохиодолд "Яаралтай тусламжийн мэргэшлийн эмч"-ийн үнэмлэх олгоно.

#### 7.3.2 Ажлын байранд суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)

**360 хэмийн үнэлгээ (*360 degree Assessment*):**

Суралцагч эмч мэргэжлийн байх (*professionalism*) болон зохион байгуулагч, манлайлагч (*leader*) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 2 жилийн сургалтын эхэн, дунд, төгсөх үед нийт 3-аас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Тойролтыг удирдсан эмнэлзүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх мэргэжилтнийг тухайн эмнэлгийн сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч эмнэлзүйн сургагч багш болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагч эмчид өгнө. Шаардлагатай тохиолдолд суралцагч эмчид ганцаарчлан танилцуулж болно.

**Mini-CEX /Эмнэлзүйн дасгал үнэлгээ (Mini – Clinical Evalution Exercise):**

Энэхүү үнэлгээ нь эмнэлзүйн ярилцлага болон үзлэг хийх үед суралцагч эмчийн ярилцлага хийх ур чадвар, бодит үзлэг хийх, эмнэлзүйн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар, чадамж эмнэлзүйн яаралтай тусламжийн эмч байх (emergency physician) болон харилцагч (communicator) байх үнэлгээг үнэлэх арга юм.

Зайлшгүй таньж мэдэх 26 шинж тэмдэг, хам шинжээс тойролт бүрт 5-аас доошгүй шинж тэмдэг, хам шинжийг тус бүр 3-аас доошгүй удаа нийт 15–аас доошгүй удаа үнэлгээ хийнэ.

Өөр тойролтонд ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно. (жишээ нь: дотрын тойролтод халуурах шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийсэн бол хүүхдийн тойролтод ч халуурах шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийж болно.)

Үнэлгээ хийх эмч нь эмнэлзүйн сургагч багш нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмнэлзүйн сургагч багш шууд ажиглаж үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж цаашид хэрхэн сайжруулах талаарх зөвлөгөөг заавал өгнө.

**Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт/DOPS (Direct observation of procedural skills):**

Зайлшгүй сурах 34 гардан үйлдлээс 24-аас доошгүйг хийж чаддаг болсныг эмнэлзүйн сургагч багш нотолж баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ. Үнэлгээ хийх эмчийг суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгогдсон эмнэлзүйн сургагч багш шууд ажиглаж үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж цаашид хэрхэн сайжруулах талаар зөвлөгөөг заавал өгнө.

**Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):**

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

### 7.4 Үнэлгээний дүнг хянах

- 360 хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж хадгална. Үнэлгээний дүнг эмнэлзүйн сургагч багш болон суралцагч эмчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Суралцагч эмч бүрийн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолио үнэлгээнд эмнэлзүйн сургагч багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч бүр нь тухайн тойролтыг дусах үед Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба нь үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

### 7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Тойролт бүрийг дуусгах үед хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэж сургалтын хяналтын зөвлөл нь тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн Mini-CEX, DOPS үнэлгээ, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүнг нэгтгэн дээр нь суралцагч эмчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний

тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан үзэж сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 80 хувийн ирцтэй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай 26 шинж тэмдэг, хам шинжээс 2 жилийн турш 20-оос доошгүйг таньж оношилж эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь:
    - Хүүхдийн яаралтай тусламжийн тойролт бүрт заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 5-аас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
    - Гэмтэгсдийг аврах лавшруулсан тусламжийн тойролтод хөтөлбөрт заагдсан зайлшгүй эзэмших болон эзэмшвэл зохих тохиолдол тус бүрээс 5-аас доошгүй удаа тохиолдол үзэж туршлага хуримтлуулсан байна.
    - Халдварт өвчний яаралтай тусламжийн тойролтод хөтөлбөрт заагдсан зайлшгүй эзэмших болон эзэмшвэл зохих тохиолдол тус бүрээс 5-аас доошгүй удаа тохиолдол үзэж туршлага хуримтлуулсан байна.
    - Эрчимт эмчилгээний тусламжийн тойролтод хөтөлбөрт заагдсан зайлшгүй эзэмших болон эзэмшвэл зохих тохиолдол тус бүрээс 5-аас доошгүй удаа тохиолдол үзэж туршлага хуримтлуулсан байна.
    - Цочмог хордлогын яаралтай тусламжийн тойролтод хөтөлбөрт заагдсан зайлшгүй эзэмших болон эзэмшвэл зохих тохиолдол тус бүрээс 5-аас доошгүй удаа тохиолдол үзэж туршлага хуримтлуулсан байна.

- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 2 жилийн сургалтын эцэст суралцагч эмчийг төгсөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалт, эрдэм шинжилгээ, гадаад харилцааны алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

## НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ХЯНАЛТ:

### 8.1 Сургалтын хяналтын зөвлөл нь:

Сургалт эрхлэх байгууллагын эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, сургалтын албаны мэргэжилтэн, яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, хүүхэд, дотор,

гэмтэл, халдварт, хордлого, мэс заслын тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн албаны төлөөлөл, суралцагч эмч нарын төлөөллөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь сургалт эрхлэх байгууллагын ерөнхий захирлын шууд удирдлага дор ажиллана.

- Сургалтын хяналтын зөвлөл нь сар бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судладаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэхийг зорьдог байна.

**8.2 Хөтөлбөрийн хяналт**

- Сургалтын алба нь хөтөлбөрийн хяналтыг хийнэ.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэлзүйн сургагч багшид чиглэсэн сургалт (faculty development), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын мэргэжилтэн хариуцан сургалтын хяналтын зөвлөлд оруулж хэлэлцүүлэн өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

**8.3 Сургалтын танилцуулга (Orientation)**

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (program) болон хөтөлбөрийн (curriculum) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх эмнэлгийн тухай, түүний үйл ажиллагаа, эмчилгээ оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

**Хавсралт1**

## 360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр______________________________

Үнэлгээ хийгч: □ Эмнэлзүйн сургагч багш, □ Сувилагч, □ Бусад _________________

*Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус суралцагч эмчийн зан үйлийг хир давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.*

| □ NA | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
|---|---|---|---|---|
| Үнэлэх боломжгүй | Ховор (≤19%) | Заримдаа (20-49%) | Ихэнхдээ (50-79%) | Бараг бүгд(≥80%) |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг. | □ ИА | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
| Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг. | □ ИА | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
| Хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг. | □ ИА | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
| Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг. | □ NA | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
| Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг. | □ NA | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
| Өөрийн эмнэлзүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг. | □ ИА | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
| Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг. | □ NA | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
| Бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажилладаг. | □ NA | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
| Эмнэлэг доторх бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилладаг. | □ ИА | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
| Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг. | □ NA | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |
| Эмнэлэг доторх тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг. | □ ИА | □ 1 | □ 2 | □ 3 | □ 4 |

**1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.**

| |
|---|
| |

**Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй.** Жишээ нь: "Тэр бол найдваргүй" гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэгдэлгүйгээр оролцсонгүй."

Өөрөөсөө асуу: **"Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?"**

**Хавсралт 2**

## ЯВЦЫН MINI-CEX ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он сар өдөр

Суралцагч эмчийн нэр: ________________

Үнэлэгчийн нэр:________________________

Сургалт эрхлэх байгууллага: ___________ Нэгж: ______ Газар: □ Клиник, □ МЗТасаг, □ МЭЭТ, □ ЯТТ

Бусад___________ Өвчтөний нас: ____________ Өвчтөний хүйс: □ Эр □ Эм

Өвчтөний зовиур: □ Халуурах, □ Шарлах, □ Толгой өвдөх, □ Ухаан санааны байдал өөрчлөгдөх, □Татах, □ Амьсгаадах, □ Ханиах, □ Цээжээр өвдөх, □ Зүрх зогсох,

□ Цустай бөөлжих, □Цустай хар өтгөн гарах, □ Дотор муухайрах /Бөөлжих,

□ Хэвлийгээр өвдөх, □ Суулгах, □ Усгүйжих, □Нуруу өвдөх, □ Саажих,

□ Сэтгэл гутрах, □ Хавагнах, □ Үе өвдөх, □ Лимфийн булчирхай томрох,

□Цус алдах, □ Амьсгал, цусны эргэлтийн зогсолт, □ Аминд осолтой зүрхний хэм алдагдалт, □ Шингэн алдалт, Бусад □ __________________________

| Сайн талууд | Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө | Бусад санал |
|---|---|---|
| | | |

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.

**Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: □**

| Үнэлгээ | Хангалтгүй | Заврын | Хангалттай |
|---|---|---|---|
| Өвчний асуумж авах | | | |
| Бодит үзлэг | | | |
| Оношилгоо, эмчилгээний менежмент | | | |
| Харилцааны ур чадвар | - | | |
| Эмнэлзүйн ерөнхий чадвар | | | |

| Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл |
|---|
| |

Үнэлэгчийн гарын үсэг ______________________ Суралцагч эмчийн гарын үсэг___________

| “Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт | |
|---|---|
| Өвчний асуумж авах | • Ялган оношилгоонд дүйхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг<br>• Өвчтөний хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг<br>• Өвчтөний дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг |
| Бодит үзлэг | • Ялган оношилгоо дүйхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг<br>• Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг |
| Эмнэлзүйн менежмент | • Зөв онош тавьдаг<br>• Оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг<br>• Тохирсон эмчилгээг эхлүүлдэг<br>• Тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг цааш нь хяналт тавьдаг |
| Харилцааны ур чадвар | • Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл саданы хүнийг сайн сонсдог<br>• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл саданы хүний зовнилыг хуваалцаж,хүндэтгэлтэй ханддаг<br>• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл саданы хүнтэй эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг |
| Эмнэлзүйн ерөнхий чадвар | • Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог.<br>• Өвчтөний таатай байдал, аюулгүй байдлыг хангахад тодорхой идэвх зүтгэл гаргадаг<br>• “Би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна!” |

**Хавсралт 3**

## ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он сар өдөр

Суралцагч эмчийн нэр: ________________

Үнэлэгчийн нэр: ______________________

Сургалт эрхлэх байгууллага: ___________ Нэгж: ______ Газар: □ Клиник, □ МЗТасаг, □ МЭЭТ, □ ЯТТ

Гардан үйлдэл: □ Амьсгалын зам чөлөөлөх, □ Зүрх, уушгины сэхээн амьдруулалт(насанд хүрэгч), □ Зүрх, уушгины сэхээн амьдруулалт (хүүхэд), □Дефибрилляц хийх, □ Артерийн судсанд гуурс тавих, □ Төвийн судсанд гуурс тавих, □ Цээжинд гаргуур тавих, □Ходоодонд хаймсуур тавих, □ Давсганд гуурс тавих,

□ Блекморын зонд тавих, □Зохиомол амьсгалд өвчтөн оруулах ба гаргах

□ Хүзүүний бэхэлгээ хийх □ Нуруу нугасны гэмтэлтэй өвчтөний бэхэлгээ хийх,

□ Монитор бэлтгэх, □ Интубац тавьж мэдээ алдуулах, □Төвөнхийн углавчтай мэдээ алдуулах, □ НХМА, □ НГХМА, □ Захын мэдрэлийн хориг, □ Хяналтын хуудас бөглөх, □ Хэт авиан түргэвчилсэн оношилгоо, хяналттай ажилбарууд гүйцэтгэх,

□ Бусад_____________________

Одоог хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо ____________

| Үнэлгээ | Хангалтгүй | Завсарын | Хангалттай | Ажиглагдаагүй/ үнэлэх боломжгүй |
|---|---|---|---|---|
| Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг. | | | | |
| Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг. | | | | |
| Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг. | | | | |
| Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг. | | | | |
| Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг. | | | | |
| Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг. | | | | |
| Шаардлагатай бичиг баримтыг гүйцэд бичдэг. | | | | |
| Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар | | | | |

Зөвлөмж:

* Сайн тал:

* Сайжруулах тал:

Бусад санал:

Сайжруулахын тулд зөвшилцөж, биелүүлэх үйлдэл:

Үнэлэгчийн гарын үсэг: ______ ________________________________

Суралцагч эмчийн гарын үсэг: ______________________________

## ЕС.НОМ ЗҮЙ


1. E.Tintinalli “Emergency medicine” 7th edition
2. Richard D.Zane “Pocket emergency medicine”
3. Robert F.Wilson “Handbook of trauma Pitfalls and Pearls”
4. John M. Field MD “Advanced cardiovascular life support”
5. John M. Field MD “PALS provider manual”
6. Kristi L. Koenig, MD “Emergency Medicine” Fifth edition
7. Justin Bowra “Emergency Ultrasound Made Easy”
8. O.John“Emergency Ultrasound”
9. Philip Wiest “Fundamentals of Emergency Radiology”
10. Г.Лхагважав “Яаралтай тусламж” 2010 он хоёр дахь хэвлэл
11. J.P.Wyatt “Oxford handbook of accident and emergency medicine”Allan. H. Goroll “Primary care medicine”
12. Brian N. Rowe “Evidence-based Emergency Medicine”
13. LATHA G.STEAD,BD,FACEP “First aid for the emergency medicine clerkship”
14. BRIAN N.ROWE “Evidence-Based emergency medicine”
15. KEVIN J.KNOOP. second edition “Atlas of emergency medicine”
16. BARBARA K. BLOK, MD “First aid for the emergency medicine bords”
17. Roderts. Hedges “Emergency medicine”
18. JR, “Emergency Medicine” Earle W. Wilkins,
19. С.А. Сумин “Неотложное состояние”. 2001. Москва. Медицина
20. Малышева В.Д., “Интенсивная терапия, реанимация, первая помощь”, Медицина 2000
21. Dr. David Pescod ба бусад “Мэдээгүйжүүлгийн сургалтын модулийн гарын авлага” 2010
22. “Эрчимт эмчилгээний үндэс” Г.Лхагважав нар англи хэлнээс орчуулсан 2009 он
23. “Орчны мэдээгүйжүүлэг” Г.Лхагважавангли хэлнээс орчуулсан 2006
24. “Основы интенсивной терапии и реанимации в педиатрии” В.А. Михельсон, А.З. Маневич 1986
25. “Физиология человека” Шмидт Р.Ф. ба Тюс Г. Англи хэлнээс орчуулсан, 2000
26. “Эмнэлгийн яаралтай тусламж”4-р хэвлэл Г.Лхагважав нар англи хэлнээс орчуулсан 2010 он
27. “Хүний биеийн физиологи” Б.Отгон
28. Сэтгэц, зан үйлийн зарим эмгэгийн яаралтай тусламж” Розен ба баркинс 5 минут
29. http://www2.warwick.ac.uk
30. https://wikem.org/wiki/Main_Page
31. http://emedicine.medscape.com/emergency_medicine
32. http://www.ajemjournal.com/